



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот


### “Нийслэлийн төр захиргааны автобааз” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 46,099,928 /дөчин зургаан сая ерин есөн мянган есөн зуун хорин найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тоёота Ландкрузер 105 маркийн, 03-22 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг “Нийслэлийн төр захиргааны автобааз” ОНӨААТҮГ-ын /Ц.Батхуяг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг актлан сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 5,000,000 /таван сая/ төгрөгнөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Нийслэлийн төр захиргааны автобааз /Ц.Батхуяг/-д үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн төр захиргааны автобааз /Ц.Батхуяг/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.



115050000153